**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 04 сарын 14 өдөр    Дугаар А/08    Эмээлтолгой

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан байгууллагын зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн ахлагч: Г.Бадамцэцэг (Нийгмийн даатгалын байцаагч)

Гишүүдэд: Т.Анударь (Тархвар зүйч)

Нарийн бичгийн дарга: Э.Эрдэнэчимэг (Хүүхэд, гэр бүл нийгмийн ажилтан)

2.Зөвлөлийн эрх, үүргийн хүрээнд холбогдох хууль, хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн шаардлага, стандарт, салбарын болон аж ахуйн нэгж, байгууллагын мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмын хэрэгжилтийн байдалд үзлэг, шалгалт хийлгэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах, үр дүнг тооцох, тайлагнаж ажиллахыг зөвлөлийн ахлагч, гишүүдэд даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн (Б.Буянхишиг)-т үүрэг болгосугай.

ДАРГА    Б.ӨНӨРБАЯР

642516021